

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдөр live.tngr.media цахим хуудсаар дамжуулан 11:00 цагаас эхлэв.

Хурлыг нээж хурлын дарга Г.Бат-Эрдэнэ хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, Тооллогын комиссын хурлын ирцийн баталгаажилтын тогтоолыг Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл уншиж танилцуулав. Хувьцаа эзэмшигчид <https://live.tngr.media> хаягаар дамжуулан 11:00 цагаас шууд дамжуулах хэсэгт байршуулсан “Ирц бүртгэл” дээр дарж ирцээ цахимаар бүртгүүлэх байсан ба цахимаар ирцээ бүртгүүлсэн хувьцаа эзэмшигч байгаагүй. Урьдчилан 3,911,337 ширхэг хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар санал өгсөн. Хуралд 3,911,337 /Гурван сая есөн зуун арван нэгэн мянга гурван зуун зучин долоо/ ширхэг буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 65.2 хувь хуралд оролцож байгааг хуралд оролцогчдод мэдээллэн компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай мэдэгдэж, хурлыг нээв.

Хурлын дарга Г.Бат-Эрдэнэ Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хэлэлцсэн нь №1:

2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах тухай;

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ:

ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулдаг. Охин компанийн бүрэлдэхүүнд Тэнгэр телевиз-ийн 80%, Анрид-ийн 66%, хараат компанийн бүрэлдэхүүнд Монгол телевиз-ийн 20%, МПЕРС-ийн 50%, болон Ори Студиос-ийн 20% компаниуд харьяалагдаж буй. Мөн Монгол телевиз ХХК-ийн бүрэлдэхүүнд 100%-иар Оримедиа ХХК харьяалагддаг. Нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж байгаа. Мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, Монголын хамгийн анхны олон нийтийн нээлттэй медиа компани гэдгээрээ онцлогтой. Түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд 2023.12.31-ний

байдлаар нийт гаргасан хувьцааны 36.4%-ийг Гэр Интерьер Дизайн ХХК, 11.8%-ийг Ард тэтгэврийн данс ХХК, 11.5%-ийг иргэн Г.Бат-Эрдэнэ, 11.5%-ийг иргэн Л.Чинбат, 11%-ийг Ард Санхүүгийн Нэгдэл ХК, 10%-ийг иргэн Н.Мөнхнасан, 4.8%-ийг бусад хувьцаа эзэмшигчид, 3%-ийг Их Бит тус тус эзэмшиж байна. 2024.12.31-ний байдлаар өөрчлөлт орсон нь 36.4%-ийг Гэр Интерьер Дизайн ХХК, 18.71%-ийг иргэн Л.Чинбат, , 13.87%-ийг иргэн Г.Бат-Эрдэнэ, 12.77%-ийг Ард тэтгэврийн данс ХХК, 10%-ийг иргэн Н.Мөнхнасан, 5.24%-ийг бусад хувьцаа эзэмшигчид, 3%-ийг Их Бит эзэмшиж байна.

Жилийн эцэст нэгжийн хаалтын ханш 5,990 төгрөг, нийт хувьцааны тоо 6 сая ширхэг, компани 36 тэрбум төгрөгөөр үнэлэгдэж байна. Компанийн бүтцийг товч танилцуулахад, Хувьцаа эзэмшигчид; ТУЗ; Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хороо; Аудитын хороо; Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо; ТУЗ-ийн нарийн бичгийн дарга; менежментэд бол Гүйцэтгэх захирал; Санхүү эрхэлсэн захирал, Нягтлан бодогч; Хуулийн зөвлөх гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд Г.Уянга, Г.Бат-Эрдэнэ, Ч.Батхүү, Б.Золбоо, Н.Мөнхнасан, А.Ундрал гишүүд ердийн гишүүдээр, В.Ганзориг, Ж.Алтангүний, Б.Наранзун гишүүд хараат бус гишүүдээр томилогдон ажиллаж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд В.Ганзориг, Ч.Батхүү, Б.Наранзун; Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороонд, В.Ганзориг, Н.Мөнхнасан, А.Ундрал, Б.Золбоо; Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд Б.Наранзун, Ж.Алтангүний, Г.Уянга гишүүд байдаг. Компанийн гүйцэтгэх менежментийн багийн хувьд Гүйцэтгэх захирлаар Ганхуягийн Бат-Эрдэнэ миний бие, Санхүү эрхэлсэн захирлаар Д.Бат-Оюун, Тэнгэр телевиз, Анрид-ийн Гүйцэтгэх захирал А.Ундрал нар ажилладаг.

Тэнгэр телевиз болон Анрид компанийн танилцуулгыг хийнэ үү хэмээн Ундрал захирлаасаа хүсч байна.

Танилцуулсан нь: Тэнгэр телевиз Гүйцэтгэх захирал А.Ундрал:

Хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Про медиа нетворк буюу Тэнгэр телевизийн хувьд 2024 онд үйл ажиллагааны тасралтгүй байдлыг, өргөн нэвтрүүлгийн мэдээний чиглэлийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа. Өнгөрсөн жилийн хугацаанд хийсэн томоохон ажлуудыг сар сараар нь гаргасан мэдээллийг хүргэе.

1-р сар: Канвон 2024 Залуучуудын өвлийн олимпын наадмыг сурвалжлан, шууд дамжуулав "Дүнжингаравын дэлбэрэлт"-ийн үеэр шуурхай мэдээ хүргэлээ

2-р сар: "Бүсчилсэн хөгжлийн форум"-ыг шууд дамжуулан хүргэж, телевизүүдэд сигнал хуваалцлаа: ХБНГУ-ын ерөнхийлөгчийн айлчлалын тусгай хөтөлбөрийг дамжуулав

3-р сар: "Боомтын сэргэлт үндэсний форум"-ыг шууд дамжууллаа. Бүсчилсэн хөгжил: Улаанбаатар арга хэмжээний шууд дамжуулалтыг гүйцэтгэлээ.

4-р сар: "Монголын багш нарын 8-р их хурал"-ыг шууд дамжууллаа "Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ" олон улсын чуулга уулзалтад 2 дахь жилдээ медиа хамтрагчаар ажиллав

5-р сар: "E-Mongolia 4.0" апп-ын шинэчлэл, нээлтийг дамжуулав. "Шинжлэх ухааны ажилчдын их хурал"-ыг шууд дамжуулав. "Crypto Week" арга хэмжээний хамтрагчаар ажиллаа.

6-р сар: "Egune AI"-ийн нээлтийн ажиллагаал шууд дамжуулав "Коломбын төлөвлөгөө байгууллагын хурал" олон улсын хурлыг шууд дамжууллаа

7-р сар: "Монголын эдийн засгийн форум 2024"-ийн медиа хамтрагчаар ажиллаж, сигнал дамжуулалт, медиа төвийн ажлыг гүйцэтгэлээ

Үндэсний их баяр наадмын сигналыг Монгол ТВ-ээс авч дамжуулсан.

8-р сар: Парис 2024 олимпын наадмын үеэр нээгдсэн "Mongolia House" төслийн медиа хамтрагчаар ажиллалаа. "Зүүн хойд азийн хотын дарга нарын чуулга уулзалт"-ыг шууд дамжууллаа

9-р сар: Дэлхийн эмэгтэйчүүдийн форумын медиа хамтрагчаар ажиллалаа. Орон нутгийн сонгуулийн сурталчилгааны ажил эхэллээ.

10-р сар: PMI Institute 2024 арга хэмжээний медиа хамтрагчаар ажиллалаа. "Парламент 2.0" арга хэмжээний нээлтийн ажиллагааны медиа хамтрагчаар ажиллалаа.

11-р сар: "Хөрөнгө оруулагч үндэстэн 2024" арга хэмжээг хамтран зохион байгууллаа. "Монголын орон сууцжуулалтын ирээдүй 2024" арга хэмжээг шууд дамжууллаа. "Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган"-ыг шууд дамжууллаа.

12-р сар: "Алтан сарнай 2024 наадмын медиа хамтрагчаар ажиллалаа. "Бөртэ Чоно 2024" наадмыг шууд дамжууллаа.

Тэрчлэн бидний хувьд CUNY, Microsoft-ийн хэрэгжүүлсэн "AI Journalism Lab" хөтөлбөрт шалгарлаа.

Time, AP, The Economist зэрэг топ редакцуудын хамтаар AI-ийн медиад үзүүлж буй нөлөө, нэвтрүүлэх шийдлүүд болон хэрэгжүүлэх боломжтой төслийн прототайп дээр ажиллав.

Шинжлэх ухааны комьюнитигийн хамгийн том цугларалт "SciCon 2024" 2 дахь жилдээ амжилттай явагдлаа.

Нийт 1000 гаруй залуус Соёлын төв өргөөнд цугларч, энэ удаагийн арга хэмжээнд 20 гаруй байгууллагатай хамтран ажиллав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудыг танилцуулав.

2024 онд явагдсан УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үеэр "Мэтгэлцээн 2024" цуврал контентийг санаачлан хэрэгжүүлж, үзэгчдээс

өндөр үнэлгээ авлаа. Нийт 30 мэтгэлцээний дугаар хийж, сошиал орчинд 20 сая гаруй хандалтыг цуглуулав.

Сэлтгүүлзүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд явагддаг хамгийн том арга хэмжээ "Алтан үзэг 2024" наадамд ивээн тэтгэгчээр ажиллав.

Танилцуулсан нь: Анрид ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Ундрал:

Анрид медиа компанийн хувьд бүтээлч контент, арга хэмжээнүүдээр дамжуулан залуучууд болон залуу мэргэжилтнүүдэд нөлөөлөх зорилготой редакц юм.

2024 оны онцлох тоонуудыг танилцуулав.

- Бид 2024 онд "Би хэрхэн ажилдаг вэ", "Өртөөлөгч", "Тайлбарлах нь", "А-Я" зэрэг контентуудаа тасралтгүй хийж 600 гаруй контент дээр ажилласан байна.
- Мөн Анрид Спешл гэх нэрэн дор илүү интеразив, мультимедиа контентуудыг бүтээж түүгээрээ дамжуулан олон шинэ хамтран ажиллах газруудыг олж үүсгэсэн.
- 2024 онд УИХ-ийн сонгуулын үеэр залуучуудын сонгуульд орох, улс төрийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор хэд хэдэн цуврал контентуудыг хийсэн. "Алдалгүй сонго" гэсэн нэрэн дор энэхүү цуврал контентуудаа бүтээсэн байгаа. Үүний дагуу нам эвсэл, улс төрийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд ажиллаж байгаа, Олон Улсын болон, Дотоодын байгууллагуудтай хамтарч ажилласан.
- Арга хэмжээний хүрээнд бид коммунити үүсгэх ажил дээр илүү анхаарч ажиллан илүү мэргэжилтнүүдэд зориулсан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.
- 2024 оны 9 сараас эхлэн Анрид Түдэй гэх нэрээр сонин гаргаж эхэлсэн. Энэ нь брендингийн хувьд Анридыг зах зээлд дахин шинээр байргуулж, хүртээмжтэй байдлаар илүү олон хэрэглэгчдэд хүргэх томоохон төсөл боллоо. Бид нийт 100 гаруй цэгээр 21 аймгийг оруулан сонингоо долоо хоног гаригуудын даваа гарагт 6000-10000 хувиар хэвлэж тарааж байгаа бөгөөд энэ нь одоогийн байдлаар Монголын сонины зах зээл дээрх нэг удаагийн хэвлэл дээр хамгийн өндөр хэв хэвлэгдэж байгаа сонин. Тараагдаж байгаа сонины тоо хэмжээний 20-25 хувийг лангаараа бүрдүүлж байгаа болтлоо өргөжсөн. Мөн бид newspaper.mn вебсайтаар дамжуулан гадаадад байгаа хэрэглэгчдийг болон дотооддоо цахимаар захиалах боломжийг бүрдүүллээ. Тусгайлсан зураг авалт контентуудыг хийж, сониныг эргүүлэн моодонд оруулах ажлуудыг хийж байна.

2024 онд хийсэн нийгмийн хариуцлагын хүрээнд дараах ажлыг хийлээ.

УНШИХ СОЁЛД УРИАЛАВ

Unread Media 2015 оноос эхлэн "алдалгүй унш" агуулгын хүрээнд, текст суурьтай контентуудыг тасралтгүй бүтээж, унших соёлыг дэлгэрүүлэх тал

дээр идэвхтэй ажиллаж байна. 2024 онд энэ үйл хэргээ долоо хоног тутмын хэвлэмэл сониноороо шинэ шатанд гаргаж, сонины соёлыг сэргээж, Монгол Улсын өнцөг буланд бүрд сониноо үнэ төлбөргүй хүргэлээ.

НОМЫН РЕДАКЦУУДЫГ ДЭМЖИЖ АЖИЛЛАВ

Сар бүрийн шинэ номын жагсаалт, Онцлох арван ном жагсаалт, Долоо хоног тутмын номын тойм нийтлэлээрээ 2024 онд 200 гаруй номыг алдаршуулж, үнэ төлбөргүй сурталчилав.

НИЙГМИЙГ ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛТӨД УРИАЛСАН ХӨТӨЛБӨР, ЭВЕНТҮҮДИЙГ ДЭМЖИВ

Unread Media компани нь нийгмийн эерэг өөрчлөлтийг өртөөлж, залуусын оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг дэмждэг уламжлалтай. 2024 онд SpaceCon, TedX Ulaanbaatar, Boosted, Youth Conference зэрэг 10 гаруй арга хэмжээний медиа түншээр ажиллалаа.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД АНХААРАВ

Unread Media нийтлэлийн бодлогоороо дамжуулан уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой ажилладаг. Энэ зорилгын хүрээнд ХААН Банктай хамтран бэлтгэдэг 2 долоо хоног тутмын цахим товхимол "2030"-ыг тасралтгүй бэлтгэн хүргэж, байгаль орчны чиглэлийн сайн туршлагуудыг алдаршуулах "Тогтвортой хөгжил" буландаа нийт 50 гаруй нийтлэлийг бичлээ.

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Э.Хүрэлтулга:

2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

- Монгол телевизийн уран бүтээлчид нийт 387,244 минут буюу 6,454 цагийн эфир үзэгчдэдээ хүргэсэн байна. Энэ нь өмнөх он буюу 2023 онтой харьцуулахад шууд дамжуулалтын эфир өссөн үзүүлэлттэй харагдаж байна. . Бид цааш цаашдаа шууд дамжуулалтын эфирийг улам их болгох, шууд дамжуулалтаа сайжруулахад анхаарч ажиллаж байна.
- Монгол ТВ телевиз нь хүүхдүүдийн авьяасыг илрүүлж, хөгжүүлэх зорилгоор дэлхий даяар алдартай "The Voice Kids" шоуны 1-р улирлыг амжилттай зохион байгуулж үндэсний хэмжээний анхны ялагчийг тодрууллаа. Ялагчаар Э.Чингүүн тодорч National life компаний Боловсролын хуримтлалын даатгалын 80сая төгрөгийн эрхийг гардуулж өглөө. Энэхүү шоу нэвтрүүлгийг 2024 оны 2-р сарын 18-аас 6-р сарын 08-ны хооронд үзэгчдэдээ хүргэсэн.
- Гэр бүлийн реалити шоу болох таныг зурагтаа үзэж байгааг зурагтаар үзүүлдэг хамгийн үзүүштэй, олон мянган үзэгчдийн хүртээл болсон "Ардын буйдан" нэвтрүүлгийн 17-р улирлыг амжилттай үзэгчдийн

хүртээл болголоо.

- 5 настнуудын нууцлаг ертөнц нэвтрүүлэг нь Монгол ТВ телевизийн хамгийн сонирхолтой хүүхдийн нэвтрүүлгүүдийн нэг бөгөөд 5 настай хүүхдүүдийн оролцоотой, тэдний оюун ухаан, бүтээлч сэтгэлгээ, авьяасыг харуулах, хүүхдүүдэд зориулсан тоглоом, даалгавар, ур чадварын шалгалт бүхий тэдний дунд өрсөлдөөн үүсгэж, олон төрлийн уралдаан зохиодгоороо онцлог юм. Тус нэвтрүүлгийн 3-р улиралыг 2024 оны 09-р сарын 15-аас эхлэн үзэгч олондоо хүргэлээ.
- Монголын хамгийн олон үзэгчтэй өглөөний хөтөлбөр "Өнөө өглөө" нь 2024 онд Нийт 47520 минутын шууд эфир буюу 264 дугаар үзэгчдэдээ хүргэжээ. Энэхүү нэвтрүүлэг нь 2012 оноос эхлэн бүтэн 12 жил тасралтгүй хүрч байна.
- Нийгмийн анхаарал, мэдээлэлд хамгийн ойрхон, үйл явдал онцлох сэдэв, шинэлэг бүхний анхдагч эх сурвалжаар дамжуулан хүргэх, ажлын өдрүүдэд шууд явагдах шинэ төсөл Terminal 1.0 нэвтрүүлэг 2024 оны байдлаар нийт 40120 минут буюу 668 цаг 40 минутын шууд эфир буюу 200 дугаарыг бэлтгэн хүргэлээ.
- Азийн телевизүүдийн шилдгийг тодруулах 29 дэх удаагийн наадамд "Монгол ТВ" телевизийн "The Voice kids Mongolia", "Авьяаслаг монголчууд" шоу нэвтрүүлгүүд нэр дэвшиж "THE VOICE KIDS MONGOLIA" шоу нэвтрүүлэг "АЗИЙН ШИЛДЭГ НУТАГШУУЛСАН КОНТЕНТ" шагналын эзэн болж Монгол ТВ 5 ДАХЬ удаагаа Азийн телевизүүдийн наадмаас шагнал хүртлээ.
- Бондын санхүүжилт, түүний хүүгээс гадна Ори Студиос төслийн хүрээнд 2024 оны байдлаар 11.5 тэрбум төгрөг гаруй хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Ори Студиос төслийг санхүүжүүлэх зорилгоор 2023 онд Монгол Телевиз ХХК 5.0 тэрбум төгрөгийн бондын санхүүжилтийг татсан. 2025 оны 1-р улиралд энэхүү бондоос 2.5 тэрбум төгрөг төлөгдөж, 2.5 тэрбум төгрөг нь 18 сарын хугацаатай дахин сунгагдсан.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудыг танилцуулав.

- Боловсрол соёлын чиглэлээр: Сонгогчийн боловсролд зориулсан Сонгуулийн Ерөнхий Хорооны 11,101 секундын, Соёл урлагийн газрын 10,805 секундын сурталчилгааг үнэ төлбөргүй дамжуулав.
- Хууль эрх зүйн чиглэлээр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 672 секундын сурталчилгааг дамжуулж, Терминал 1.0 хөтөлбөрөөр долоо хоног бүр иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан хуулийн буланг эрхлэн явуулж байна.
- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: "Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд өсвөр үеийнхнийг хамгаалцгаая"сэдэвт хэлэлцүүлгийг Нийгмийн хариуцлагын хүрээнд Нүүдэл шийдэл нэвтрүүлгээр оруулсан болно.
- Креатив салбарыг дэмжих чиглэлээр: Монголын маркетингийн

холбооноос хэрэгжүүлж буй ажлуудын талаар мэдээлэл хүргэсэн.

- Бусад: 2024 онд өнөө өглөө хөтөлбөрт нийт 37-н дугаарт нийгмийн хариуцлагын хүрээнд зочин оролцуулсан.
- Нийгэм, эдийн засгийн чиглэлээр: Нийгмийн залуу манлайллыг танилцуулах зорилго бүхий Кандидат нэвтрүүлгийг бэлтгэн хүргэв. /1-р улирал 8 дугаар/

Ори Медиа ХХК компанийн үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг хийнэ үү хэмээн Гүйцэтгэх захирал Н.Сансараас хүсч байна.

Танилцуулсан нь: Ори Медиа ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Сансар:
Эрхэм хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Онцгой бүтээлийг ОРИ-гоос, үргэлжлэлийг Оригоос гэх уриатай, нийт 8 ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Ори Медиа ХХК нь 2024 онд Контентын харилцагч буюу дистрибьютор компани 5 байсан бол 9 харилцагч компанитай болж нэмэгдсэн.болж нэмэгдсэн

Контентын тоог нэмэгдүүлж чадсан амжилттай явж байна. Нийт контентын тоо 9800 12384 болж нэмэгдэж, үзэгчиддээ хүргэх илүү олон контентуудтай болсон.

Мөн Ори Медиагийн хэрэглэгчдэдээ үндсэн багцаа сайжруулах зорилгоор түлхүү ажилласан. Манай нийт ихэнх хэрэглэгчид нь гадаадад суугаа хэрэглэгчид байдаг тул хуучны кино контентуудыг мөн багц сувгуудаа нэмэгдүүлэ, 7 хоног бүр 2-4 шинэ кино нэмэгддэг болсон.

Бидний год амжилттай хийгдсэн ажлууд бол Орлого хуваарилах журмаар хамтран ажилладаг. Үүгээр харилцагч уран бүтээлчдээ дэмжих зорилгоор "Уран бүтээлчид Оригоос орлогоо 100% авдаг боллоо гэх хөтөлбөрийг хэрэгжүүлээд" энэ хөтөлбөрийн хүрээнд Тасалбартай кинонууд Үндсэн зино багцруу 4-6 сарын дотор ордог болсон. Энэ нь шинэ кино хийгээд хагас жилийн дотор нийт борлуулалтаа хийгээд авдаг. Энэхүү орлогыг нь орлого хуваарилах журмаар авах гэхээсээ илүүтэйгээр уран бүтээлчидээ илүү сайн дэмжих, орлогыг нь 100% олгох гэдэг зарчмаар хамтран ажиллах нь илүү үр дүнтэй юм баяа. гэж үзсэн.

Мөн Ори апплекэйшн дээр Караоке дуул багцтай болсон бөгөөд 40006 дууны сантай болсон. Үүнийг зурагтан дээр Ори апплекэйшнээ татаад дуулах боломжтой болгосон.

Мөн төлбөр төлөлтийг илүү хялбар болгож өгсөн. Хаан банк, DIGI PAy болон Нiрау, бүх банкны апплекейшнээр төлбөрөө төлөх боломийг нь бүрдүүллэв.

Мөн бүх оддын тоглолт болон Гавъяатын найр, зэргийг Оригийн хэрэглэгчид шууд лайваар үзэх боломжийг бүрдүүлсэн.

Бид Нийгмийн хариуцлагын хүрээнд Уран бүтээлчдийн бүтээлийг сошиал орчинд 1240 тохиолдолд овуны өмчийг хамгаалж ажилласан.

МПЕРС ХХК компанийн үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг Гүйцэтгэх захирал Г.Хасбазар хийнэ.

Танилцуулсан нь: МПЕРС ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Хасбазар:
Эрхэм хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

2022 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа. ингээд 3 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Бид Монгол Телевизээр бүтэнсэйн болгон 11 цагаас Өнөө өглөө гэх нэвтрүүлгийн үеэр гарч байгаа. 2024 оны үед бид "Боломжийг атга" гэх уриатайгаар үйл ажиллагаагаа явуулсан.

Апп болон вэб сайтын UI (User Interface) болон UX (User Experience) дизайныг шинэчилж, хэрэглэгчдэд илүү хялбар, эерэг туршлага бий болгохоор анхааран ажиллав. Илүү хялбар болгож, илүү олон функцтэй болсон. Өнгө маань ногоон өнгөтэй болгосон. Энэ нь азыг бэлгэшээдэг юм.

Мөн бид Хонворыг зардлыг олголт хийсэн дүнгээс тооцдог байсан бол одоо нийт хожсон дүнгээс хасаж олгодог болж, илүү шударга ба ил тод тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн.

2024 онд 6/42 лоттонд нийт 11,755 харилцагч оролцсоноос 5,383 нь мөнгөн шагнал хожсон.

Энэ нь оролцсон хэрэглэгчийн 46%-д нь ямар нэгэн урамшуулал ногдсоныг харуулж байна. Нийт бүртгэлтэй 37,000 хэрэглэгчтэй харьцуулбал, 31.8% нь идэвхтэй оролцсон байв. Ийм өндөр хожлын магадлалтай үндэсний лоттонд хамрагдсан тэдгээр мянга мянган хэрэглэгчид амжилт, азын үнэн бодит жишээ болон үлдлээ.

Бид Нийгмийн хариуцлагын хүрээнд 6/42 Лотто болон "Veloo foundation" сайн үйлсийн сантай хамтран хүүхдүүдийн ирээдүйг дэмжих, тэдний боловсрол, эрүүл мэндийг сайжруулах хандивын үйл ажиллагааг өрнүүлж байна. Бид орлогынхоо тодорхой хувийг энэхүү хүүхэд хамгаалах санруу шилжүүлдэг болсон.

Ори Студиос ХХК компанийн үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг Гүйцэтгэх захирал Д.Бат-Оюун хийнэ.

Танилцуулсан нь: Ори Студиос ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Бат-Оюун:
Эрхэм хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Бид 2024 онд нийт бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж, эхнийхээ 2000 заалыг ашиглалтанд оруулж, 2024 оныг ихээхэн амжилт дүүрэн үдсэн билээ.

Оны эхнээс оныг дуусах хүртэл бүтээн байгуулалтын ажил тасралтгүй явагдсан. Үүнтэй зэрэгцүүлэн хөрөнгө оруулалт босголтын ажил зэрэг хийгдээд явуулсан

Зургуудаас харахад бүтээн байгуулалтын ажлыг сар сараар салган харуулсан байна. Монгол Улсад бүрэн акустикийн шийдэлтэй 2000-ийн хэмжээтэй заал үйл ажиллагаагаа явуулаад эхэлсэн байгаа.

Бид хэд анхнаасаа төлөвлөхдөө олон улсын стандартад нийцсэн, кино уран бүтээл авах зориулалттай байхаар төлөвлөж хийсэн бөгөөд, энэхүү төлөвлөгөөнийхөө дагуу студиэ ашиглалтад оруулсан банья.

Бид хараат бус редакцын бодлоготой медиа сувгуудыг хөгжүүлнэ гэсэн зорилгын хүрээнд энэхүү студийг хийж эхэлсэн. Үүний сацуу Уран бүтээлчдийг нэгтгэсэн талант хабын платформыг гаргасан байна.

ОРИ СТУДИОС вэб сайтын нээлтийн хүрээнд Монголын кино зөвлөл, дотоодын болон гадаад урлаг соёлын хүндтэй 10 гаруй зочдыг уригдан оролцсон.

Студийг ашиглалтанд оруулан үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлээр ажиллаж эхэлсэн бөгөөд

Хаан банкны үйл ажиллагануудыг тогтмол байдлаар зохион байгуулж хамтран ажиллаж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудыг танилцуулав.

Ургах наран хорооллын 200-р цэцэрлэгийн бяцхан сурагчдад оюуны хөрөнгө оруулалт болгон ном хандивлаж, хүүхдийн боловсрол, танин мэдэхүйд үнэтэй хувь нэмэр орууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 100 хүүхдэд өвлийн аялал, адал явдлаар дүүрэн дурсамж бүтээх боломж олгон Ори Винтер Паркын тасалбарыг бэлэглэсэн нь хүүхдүүдийн сэтгэл ханамж, баяр баяслыг бадраасан сайхан үйл явдал боллоо.

Ургах наран хорооллын эрчим хүчний дутагдалтай нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд, өндөр хүчдэлийн эрчим хүчний эх үүсвэрийг авчирч, оршин суугчдын амьдрах орчин, хэрэглээг сайжруулахад бодитой хувь нэмэр үзүүлэв.

Баянзүрх дүүргийн 11-р хорооны жилийн тайлангийн үйл ажиллагааг Ори Студи-д амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, олон нийтийн хамтын ажиллагаа, ил тод байдлыг хангахад хувь нэмрээ орууллаа.

Танилцуулсан нь: Г.Бат-Эрдэнэ

Дараагийн хэсэгт 2024 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулах бөгөөд Хүлэгтхүннү Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа захирал хүрэлцэн ирсэн байна.

Танилцуулсан нь: Тэнгэрлиг Медиа Групп ХК-ийн ГСанхүү эрхэлсэн захирал Д.Бат-Оюун:

Хүлэгтхүннү аудит нь Тэнгэрлиг медиа группт 2 дахь жилдээ аудит хийж байгаа бөгөөд өнөөдөр Хүлэгтхүннү аудитын компанийн гүйцэтгэх захирал Аудитын тайланг танилцуулах ёстой байсан ч, эрүүл мэндийн шалтгаанаар ирэх боломжгүй болсон тул аудитын компаниас хүргүүлсэн аудитын тайланг та бүхэндээ би танилцуулахаар боллоо. Аудитын тайланг Монголын хөрөнгийн биржийн вебхуудас болон компанийн веб хуудаст нийтэлнэ.

Бид компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдал уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт-ын дагуу үнэн зөв бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэлтийг өгсөн байна.

Тэнгэрлиг медиа групп ХК-ийн хувьд охин болон хараат компанидаа менежментийн зөвлөгөө өгөх зорилгоорүүсгэн байгуулагдсан дотооддоо их хэмжээний үйл ажиллагаа хийгддэггүй. иймд охин болон хараат компанидаа менежментийн төлбөрийн дарамт учруулахгүйн тулд 2024 онд менежментийн зардлыг танаж ажилласан.

Санхүү байдлын тайлангийн хувьд эздийн өмч 18,411 тэрбум байсан бол 2024 онд 18,366 0.24 хувиар буурсан 2023 онд 18.3 тэрбум төгрөгөөр тайлагнагдаж байсан бол 2023 онд урт хугацаат хөрөнгө оруулалттай холбоотойгоор 0.42 хувийн өсөлттэй байсан үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн менежментийн зардлыг бууруулсантай холбоотойгоор өмнөх оныхоос сөрөг буюу 45 саяаар гарсан, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ 797 сая болон нэмэгдэж гарсан. Мөнгөн хөрөнгө буурсанаар гарсан банья.

Танилцуулсан нь: Г.Бат-Эрдэнэ

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд хангалттай сайн гэсэн дүгнэлт өгснийг дэлгэрэнгүй танилцуулав.

Танилцуулсан нь: Г.Бат-Эрдэнэ

2025 оны 01 сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрээр компанийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны цар хүрээг тэлж байгаатай холбогдуулан 2025 онд Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг гаргасан байна.

Хувьцаа эзэмшигчдээс асуулт ирээгүй тул санал хураалт явуулав.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

ТОГТООЛ 1:

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 3,911,337 ширхэг буюу 65.2 хувийн хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд Хурлаар 3,911,337 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгснөөс:

1.1. Зөвшөөрсөн: 3,911,337 ширхэг буюу 100%

1.2. Татгалзсан: Байхгүй

1.3. Түдгэлзсэн: Байхгүй байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

ХЯНАСАН:
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Г.БАТ-ЭРДЭНЭ

Э.ХАЛИУНГОО

